

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Премиум Нэксус ХК (“Компани”), түүний охин компаниуд болох Сэнтрал Фүүдс ХХК, Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК, Стора Централ ХХК, Премиум Коммерс ХХК, Премиум Нэксус Ложистикс ХХК (хамтад нь “Премиум”) болон Премиумын гэрээт компани, туслан гүйцэтгэгч, (хамтад нь “Оролцогч талууд”) -ын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн бүс нутаг дах соёлын биет болон биет бус өв, засаг захиргаа, оролцогч талууд, оршин суугчид, орон нутгийн ард иргэдтэй харилцах харилцааг энэхүү Нийгмийн хариуцлага, олон нийтийн харилцааны талаар баримтлах бодлого (“Бодлого”) -оор зохицуулах бөгөөд үүнд Компанийн нийгмийн хариуцлагатай холбоотой үйл ажиллагаа явуулахдаа мөрдөж ажиллах шаардлагуудыг зааж өгсөн болно.
- 1.2. Премиумын төслийн цар хүрээ онцлог, тухайн төсөлд мөрдөж байгаа стандартаас хамаарч энэхүү бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд Премиумын бусад бичиг баримттай уялдан хэрэгжүүлнэ.
- 1.3. Энэхүү бодлогыг нийтэд ил тод байлгана.

2. ЗОРИЛТ

- 2.1. Премиум нь үйл ажиллагаа явуулж байгаа тухайн бүс нутагт хүрээлэн буй орчин болоод нийгэмд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй бөгөөд хамгийн боломжит бага төвшинд байлгах зорилтыг хангахад оршино.

3. ЗОРИЛТОД ХҮРЭХ АРГА ЗАМ

- 3.1. Зорилтдоо хүрэхийн тулд бид үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт дараах ажлуудыг хийнэ. Үүнд:
 - 3.1.1. Орон нутгийн ард иргэд, засаг захиргаа, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай нягт харилцан ажиллах төлөвлөлтүүдийг боловсруулан санал гомдлыг нээлттэй хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, тайлагнах,
 - 3.1.2. Орон нутгийн хууль, дүрэм журмыг хүндэтгэн, чанд мөрдөж ажиллах,
 - 3.1.3. Орон нутагт явуулах тусламжийн болон сайн үйлсийн аян, орон нутагтай хамтран хэрэгжүүлэх төслүүдийг боломжтой, зохистой хэлбэрээр дэмжиж ажиллах,
 - 3.1.4. Орон нутгийн засаг захиргаа, иргэд, төрийн болон бусад холбогдох байгууллагуудтай оролцогч талуудын төлөвлөлтийн дагуу болон бусад шаардлагатай үед уулзалт зохион байгуулж үйл ажиллагаа болон хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар танилцуулах, мэдээллээр хангах,
 - 3.1.5. Орон нутгийн аж ахуй нэгжтэй бизнесийн ёс зүйтэй хамтран ажиллах,
 - 3.1.6. Премиумын нийт ажилчид ямагт хувь хүний зан төлөв, ёс суртахууны стандартыг хангаж ажиллах,
 - 3.1.7. Орон нутгийн өмч хөрөнгө, мал сүрэг, байгаль, байгалийн дахин давтагдашгүй үзэсгэлэнт газар, соёлын өв, түүхийн дурсгалт газар, гол горхи, булаг шанд, нуур цөөрөм, гол мөрөн, ан амьтад зэргийг хамгаалж хүндэтгэлтэй хандах шаардлагатай тохиолдолд дээрх ажлуудад тусламж дэмжлэг үзүүлэх,

- 3.1.8. Боломжтой тохиолдолд орон нутгийн компаниудтай хамтран ажиллаж, тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах.

4. ГҮЙЦЭТГЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- 4.1. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд нь дараах зүйлс байна. Үүнд:
- 4.1.1. Орон нутаг, оролцогч талуудаас ирсэн санал, гомдол, хүсэлтүүдэд яаралтай хариу өгөх, шийдвэрлэлт,
- 4.1.2. Премиумын болон салбар компани, төслүүд орон нутаг, оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө боловсруулж ажиллах, төлөвлөгөөний биелэлтээр.

5. ОРОН НУТАГ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ БАГ

- 5.1. Премиум нь үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагтаа түүнийг төлөөлж засаг захиргаа, бүс нутгийн иргэдтэй харилцах багтай байна. Багийн гишүүдийг Гүйцэтгэх захирлын тушаалаар орон тооны бус гишүүдийг томилно.

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛУУД

- 6.1. Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагт байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгүүлж хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.2. Шинээр хэрэгжих төсөл, үйл ажиллагаанд байгаль орчны үнэлгээ урьдчилан хийж тухайн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх дүгнэлтийг гаргана.
- 6.3. Хүрээлэн буй орчинд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан сөрөг нөлөөтэй аливаа төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй тухайн үйл ажиллагаа, төслийг зогсооно.

7. ОЛОН НИЙТ, ОРОН НУТАГТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

- 7.1. Зөвлөлдөх
- 7.1.1. Премиумын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бүс нутгийн засаг захиргаа, иргэд, малчид, орон нутгийн удирдах байгууллагын төлөөлөлтэй зөвлөлдөнө.
- 7.1.2. Төслийн захирал болон орон тооны бус гишүүд нь орон нутагтай нягт харилцаатай ажиллаж аливаа асуудлыг шийдвэрлэх ба орон нутагт нөлөө үзүүлж болох үйл ажиллагааны талаар цаг хугацаанд нь сануулга өгч ажиллана.
- 7.1.3. Үйл ажиллагаатай холбоотой үүссэн асуудлыг бүх оролцогч талуудын санал, сэтгэгдлийг нээлттэй сонсож бүс нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөв гарц санал санаачлаг гаргана.
- 7.1.4. Гомдол, саналыг албан ёсны маягтаар хүлээн авна (Хавсралт 1).
- 7.1.5. Маягт болон дэлгэрэнгүй мэдээллийг санал гомдлын бүртгэлд бүртгэж, тэмдэглэл хөтлөн баримтжуулах бөгөөд авсан арга хэмжээг баримтжуулан Премиумын архивд хүлээлгэн өгнө.
- 7.2. Харилцах
- 7.2.1. Орон нутагтай харилцах харьцаа нь дараах хэлбэрээр байж болно. Үүнд:
- Нээлттэй хаалганы өдөр,
 - Орон нутагтай хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус уулзалт,

- Буяны арга хэмжээ, сайн үйлсийн аян,
- Мэдээлэл, зарлал,
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл,
- Ухуулах материал.

- 7.2.2. Орон нутаг, олон нийттэй харилцах харилцаанд шаардлагатай эсвэл боломжтой туслалцааг хуулийн хүрээнд үзүүлж болно.
- 7.2.3. Орон нутаг, олон нийттэй харилцах харилцаанд туслалцаа дэмжлэг үзүүлж буй тохиолдолд Премиумын Ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.
- 7.2.4. Орон нутаг, олон нийтийн санаачилгуудыг гомдол, санал хүсэлтийн маягт ашиглан бүртгэж, авсан арга хэмжээ, хэрхэн шийдвэрлэсэн талаар баримтжуулан архивлана.

8. ОЛОН НИЙТ, ОРОН НУТАГТ МЭДЭЭЛЭХ

8.1. Мэдээлэх

- 8.1.1. Групп болон төрөөс хуульчилж өгсөн шаардлагуудын дагуу орон нутаг болон Премиумын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээ мэдээлэл, үйл явдлын талаар орон нутгийн холбогдох байгууллагуудад мэдээлнэ.
- 8.1.2. Төслийн захирлаар дамжуулан өмч хөрөнгө, мал сүрэг, байгалийн дахин давтагдашгүй үзэсгэлэнт газар соёлын өв, түүхийн дурсгалт газар, гол горхи, булаг шанд, нуур цөөрөм, гол мөрөн, ан амьтанд учруулсан аливаа хохирлын талаар Премиумын удирдлагад яаралтай мэдэгдэнэ.

8.2. Ашигт малтмал, амьтан, ургамлын үлдэгдэл болон археологийн олдвор бүхий газрууд

- 8.2.1. Премиумын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй талбайгаас олдсон аливаа олдвор, амьтан, ховор, нэн ховорт тооцогдох ургамал, түүхийн үнэт зүйлс, археологи, антропологийн олдвор, үнэт металл, үнэт чулуу гэх мэт зүйлс нь тухайн орон нутгийн өмч байна. Аливаа олдвор олдсон үед тэдгээрийг хамгаалалтад авах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн зураг, дүрс бичлэгээр баримтжуулан олдворын талаар холбогдох орон нутгийн болон төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

9. ХУВИЙН ЗАН ҮЙЛ

9.1. Танилцуулга сургалтын үеэр дараах шаардлагуудын талаар онцлон танилцуулна. Үүнд:

- 9.1.1. Монгол улсын хууль болон олон улсын гэрээ, тэдгээртэй дүйцэхүйц эрх зүйн бусад актаар хориглосон галт болон хүйтэн зэвсэг, зэвсгийн чанартай эд зүйлс, тэсэрч дэлбэрэх бодис, согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг биедээ авч явах, бусдад зарж борлуулахыг хатуу хориглох бөгөөд гэрийн тэжээвэр, зэрлэг амьтдыг төслийн болон үйл ажиллагаа явуулж байгаа талбайд нэвтрүүлэхийг хатуу хориглоно,
- 9.1.2. Бүх төрлийн зэрлэг ан амьтан, жигүүртний төрлийн амьтад, хэвлээр явагчдыг барих болон гаршуулан тэжээхийг хуулиар хориглодог бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагт дээрх амьтад орж ирсэн тохиолдолд төслийн захирал, байгаль орчин хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэнэ,
- 9.1.3. Зэрлэг амьтан, болон байгаль орчинд санаатайгаар хор хохирол учруулах үйлдэл хийхийг хатуу хориглоно,
- 9.1.4. Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн ард иргэдтэй хүндэтгэлтэй харьцаж,

ан амьтан, мал сүрэгт аюул хор учруулахгүй, айлгаж үргээхийг хориглоно,

- 9.1.5. Премиумын ажилтны хувийн зан үйлтэй холбогдон гарсан аливаа зөрчлийг төслийн захиралд мэдэгдэж, шалтгааныг судлах бөгөөд судалгааны тайланг бүх оролцогч талуудад мэдээлнэ. Асуудалд холбогдсон тухайн ажилтанд сахилгын арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд тухайн төслийн талбайд ажил үүрэг гүйцэтгэхийг хориглох арга хэмжээг авна.
- 9.1.6. Нийт ажилтнууд төслийн талбайд Премиумын ёс зүйн дүрмийг чандлан баримтлан ажиллана.

